



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2020 оны 04 сарын 21 өдөр

Дугаар 146

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө нээлттэй  
дуудлагын худалдаагаар дахин  
худалдах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 3, 44 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг 2019 оны “Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай” 268 дугаар тогтоолын 4.4 дэх заалт, “Мэдээ тайлангийн маягт батлах тухай” 269 дүгээр тогтоолын 2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Баянхонгор аймаг дахь Политехникийн коллежийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, нийт 7,615,900.00 /долоон сая зургаан зуун арван таван мянга есөн зуун/ төгрөгийн балансын үнэ бүхий 2 ширхэг автомашиныг дуудлагын худалдаагаар дахин худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу шинэчлэн тогтоосугай.

2. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Өнөрбаяр, Баянхонгор аймаг дахь Политехникийн коллежийн захирал Д.Бат-Орших нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Үндсэн хөрөнгийг дуудлагын худалдаагаар худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Дуудлагын худалдааг зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулах, дуудлагын худалдаанаас олох орлогыг (дуудлагын худалдааны зардлыг хассан дүнгээр) зохих журмын дагуу улсын төсөвт төвлөрүүлэх;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.4. Энэ тогтоолын биелэлтийг холбогдох мэдээ тайлангийн маягт, хөрөнгийн үнийг төвлөрүүлсэн баримтын хамт 2020 оны 3 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.


ДАРГА

З.МЭНДСАЙХАН

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН  
ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР  
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2020 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн  
1/А.6 дугаар тогтоолын хавсралт



Баянхонгор аймаг дахь Политехник коллежийн үндсэн хөрөнгөд  
бүртгэлтэй нээлттэй дуудлагын худалдаагаар дахин худалдах автомашин

Д/д	Автомашины марк, улсын дугаар, арал	Үйлдвэрлэсэн, ашиглалтад орсон он	Нийт гүйлт /км/	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэх өртөг (төгрөг)	Сэргээн босголт (төгрөг)	Худалдах доод үнэ (төгрөг)
1	Аксент, 76-46 БНА, арал № 034901	1994/ 2001	98560	4,615,900.00	4,615,900.00	0	0	200,000.00
2	Аксент, 50-89 БНА, арал № 014782	1996/ 2003	90263	3,000,000.00	3,000,000.00	0	0	200,000.00
	Нийт дүн			7,615,900.00 /долоон сая зургаан зуун арван таван мянга есөн зуун/	7,615,900.00 /долоон сая зургаан зуун арван таван мянга есөн зуун/	0	0	400,000.00 /дөрвөн зуун мянган/